



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/60

Мандалговь

“Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний 2 дахь  
шатны судалгаа” зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгын газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусlamж дэмжлэг үзүүлэх журам”-ын 3.1 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын А/57 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээний түр журам”-ын 3.7 дахь хэсэг, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварт “Ковид-19” цар тахлын үед хүүхэд, гэр бүлд тулгамдсан асуудлыг судалж, богино хугацаанд шийдвэрлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор “Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний 2 дахь шатны судалгаа”-г зохион байгуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ны өдрийн хоорондох хугацаанд зохион байгуулсугай.
2. “Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний 2 дахь шатны судалгаа”-г зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 115.200 (Нэг зуун арван таван мянга хоёр зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190119



Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын даргын 2021 оны дугаар сарын  
30-ны өдрийн дугаар тушаалтын дүгээр хавсралт

0820070004  
2034137 4-CBT1714

“ЭРСДЭЛИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ 2 ДАХЬ ШАТНЫ СУДАЛГАА”  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бужинлхам

Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч

Гишүүд:

Б.Цэцэг

Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн

Р.Мөнхбат

Захиргаа хүний нөөц, хариуцсан ахлах  
мэргэжилтэн

Д.Саранзаяа

Хяналт, шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан  
хариуцсан мэргэжилтэн

Э.Мөнхжаргал

Хүүхдийн оролцоо, зуслангийн үйл  
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Х.Төмөрбат

Залуучуудын хөгжлийн төвийн ажлын  
албаны нарийн бичиг

Т.Насандэлгэр

Залуучуудын хөгжлийн төвийн сургалт  
хариуцсан ажилтан

Б.Мөнх-Оргил

Архив бичиг хэрэг, олон нийт хариуцсан  
ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын  
30 ны өдрийн 06 дугаар тушаалын 06 дугаар хавсралт

0820070004  
9034137 CSST11714

ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

| №    | Бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|------|--------------|-------------|------------|----------------|----------|
| 1    | Утасны нэгж  | тоо         | 8          | 14400          | 115200   |
| Нийт |              |             |            |                | 115200   |